

БАТЛАВ  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ДАРГА   
Ж.ГАНБААТАР  
2023 оны 05 дугаар сарын...-нд

ЦЭРГИЙН ШТАБ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС,  
ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ МОНГОЛ ЦЭРГИЙН НЭГДСЭН ХОЛЬООТОЙ  
ХАМТРАН СУМДАД АЖИЛЛАХ УДИРДАМЖ

2023.05.15

**ЗОРИЛГО:** Хүүхэд, залуучуудад тусгаар тогтнол, эрх чөлөөний үнэ цэнийг ойлгуулах, эх орноороо болон Монгол хүн болж төрснөөрөө бахархах, эх байгаль, түүх соёлоо хайлран хамгаалах ухамсартай иргэнийг төлөвшүүлэх, цэргийн албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах болзол хангасан 1997 онд төрсөн иргэдтэй уулзаж төлбөр тогтоож мэдэгдэх хуудас хүргүүлэх, бодлогын баримт бичгийн төлөвлөлт хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх.

**ОРОЛЦОХ БҮРЭЛДЭХҮҮН:**

Цэргийн штабын дарга хурандаа Н.Хүрэлээ, ХШҮ-ний хэлтсийн дарга Ц.Ганчимэг, Цэргийн штабын дайчилгааны офицер дэд хурандаа Л.Цэнддорж, ХШҮ-ний хэлтсийн мэргэжилтэн Б.Ундрахжаргал, Хэнтий аймаг дахь Монгол цэргийн нэгдсэн холбооны нарийн бичгийн дарга бэлтгэл дэд хурандаа Ц.Батсайхан

**ЯВАХ МАРШРУТ:**


Өмнөдэлгэр, Батширээт, Гурванбаян, Биндэр, Баян-Адарга, Дадал, Норовлин, Батноров, Баян-Овоо, Бэрх сум, тосгодод 2023 оны 05 дугаар сарын 15-наас 21-ныг дуустал хугацаанд

**ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ:**

- “Бидний бахархал” арга хэмжээг сумдын ЕБС-ийн сурагчдын дунд зохион байгуулах
- Цэргийн албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах болзол хангасан 1997 онд төрсөн иргэдтэй уулзаж төлбөрийг тогтоох, төлүүлэх.
- Бодлогын баримт бичгийн төлөвлөлт, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, Тамгын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, уялдаанд үзлэг явуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх.

**СУМДЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР:**

- Баталсан хуваарийн дагуу арга хэмжээнд оролцох сурагчдыг бэлэн байлгах.
- Арга хэмжээ болох байрыг зориулалтын дагуу бэлтгэх.
- Цэргийн албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэдийг тогтоосон газар бэлэн байлгах.

ЦЭРГИЙН ШТАБЫН  
ДАРГА ХУРАНДАА  Н.ХҮРЭЛЭЭ

